

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ДУГААР 151011
ХАВСРАЛТ 0
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00–10:45 цагт Zoom программ ашиглан цахимаар хуралдуулав. Хурлын шууд дамжуулалтыг Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Худалдааны Төв, 4-р давхарт, Өргөө 3 кино театр, 4-р танхимаас, Хурлын ирц бүртгэл болон санал хураалтыг Си Эм Си Консалтинг ХХК-ийн хөгжүүлсэн программ хангамжийг ашиглан явуулав.

Хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн дарга А.Ганхуяг, Хурлын Тооллогын комиссоор Алেকс Капитал ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Лхамдолгор (дарга), Хуульч П.Сэлэнгэ, Брокер Т.Энх-Амгалан нар, Хурал зохион байгуулах комиссоор Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг (дарга), ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга, Бизнес хөгжлийн менежер Г.Батбаатар, Нягтлан бодох бүртгэлийн менежер Б.Ганзориг, Маркетингийн ахлах мэргэжилтэн Б.Ууганболд нар тус тус ажиллав. Хуралд ТУЗ-ийн гишүүд А.Ганболд, Г.Бат-Эрдэнэ, О.Батмөнх нар мөн оролцов.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 686,026,806 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 817,768,643 ширхэг энгийн хувьцааны 83.89 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлж Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 83.89 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, Хурлын дэг болон Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

- (i) Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх;
- (ii) Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх;
- (iii) Компанийн Дүрмийг батлах;
- (iv) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Хурлын дарга Тооллогын комиссыг Хуралд санал өгөх журмыг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлаар хэлэлцэх 1-3 дугаар асуудлыг ердийн аргаар санал хураах ба хувьцаа эзэмшигчид нь эдгээр асуудалд "Зөвшөөрсөн", "Татгалзсан" эсвэл "Түдгэлзсэн" ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд ☒ тэмдэглэгээг хийж санал аа өгөх, харин Хурлаар хэлэлцэх 4 дүгээр асуудлыг кумулятив аргаар санал хураах тул хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байж хувьцаа эзэмшигчид саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй тухай танилцуулав.

ДУГААР 151011
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

Хурлын дарга хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргаас хүсэв. Хурал зохион байгуулах комиссын дарга нь Хуралтай холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох үүднээс Хурлын зарыг 2021 оны 11-р сарын 22-ны өдөр, давтан зарыг 2021 оны 12-р сарын 07-ны өдөр тус тус Өнөөдөр сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар, мөн Хурлын танилцуулга материал буюу Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 151021-18 тоот тогтоол, Хурлын зар, Хурлаас гарах шийдвэрийн төсөл, Компанийн Дүрмийн төсөл, ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга, Хурлын саналын хуудас болон Хуралд оролцож, санал өгөх зааврыг 2021 оны 11-р сарын 22-ны өдөр Компанийн цахим хуудаст байршуулж, брокерын компаниуд болох Голомт Капитал ХХК, Апекс Капитал ХХК-д хүргүүлснийг дурдаад дараахыг танилцуулав.

1. КОМПАНИЙГ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛГОХ ЗАМААР ХЭЛБЭРИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаа амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан энэхүү Хурлыг зарлан хуралдуулж Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтыг дагуу Компанийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилж, Компанийн оноосон нэрийн ард Компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК" гэсэн ялгах тэмдэглэгээтэй болох тухай Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

2. КОМПАНИЙН ОРШИН БАЙГАА ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг 2021 оны 09-р сарын 01-ний өдрөөр Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт шилжүүлсэнтэй холбогдуулан Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалтад заасны дагуу Компанийн оршин байгаа хаягийг өөрчилж Компанийн дүрэмд тусган улмаар холбогдох бүртгэх байгууллагуудад бүртгүүлэхээр төлөвлөсөн тухайн Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

3. КОМПАНИЙН ДҮРМИЙГ БАТЛАХ

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох зөвшөөрлийн дагуу хоёрдогч зах зээлийн арилжааг амжилттай эхлүүлж хувьцаат компани болж байгаатай холбогдуулан Компанийн дүрмийг шинэчлэн найруулсан бөгөөд Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтын дагуу тус шинэчлэн найруулсан дүрмийг Хурлаар хэлэлцүүлж батлуулан холбогдох бүртгэх байгууллагад бүртгүүлэх тухайн Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

4. КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

Компани нь Хорооны холбогдох зөвшөөрлийн дагуу хоёрдогч зах зээлийн арилжааг амжилттай эхлүүлж хувьцаат компани болж байгаа, мөн Компанийн дүрмийн төсөлд заасны дагуу ТУЗ-ийн

ДУГААР 151011
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

есөн гишүүнтэй, гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтуудыг үндэслэн Адилбиш овогтой Ганхуяг, Адилбиш овогтой Ганболд, Гансүх овогтой Бат-Эрдэнэ, Очирбат овогтой Батмөнх, Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ, Ганболд овогтой Чинзориг нарыг ТУЗ-ийн ерийн гишүүнд, Равжин овогтой Ганболд, Чулуун овогтой Мэргэн, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж байгаа тухай Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

Хурлаар хэлэлцэж буй асуудлаар асуулт байгаа эсэхийг Хурлын дарга асуув. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс аливаа асуулт байхгүй тул Хурлын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурлын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтыг дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. **Компанийн хэлбэрийг өөрчлөх:** зөвшөөрсөн 682,621,600 ширхэг хувьцаа буюу 99.99 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 1,007 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь байна.
2. **Компанийн хаягийг өөрчлөх:** зөвшөөрсөн 682,621,422 ширхэг хувьцаа буюу 99.99 хувь, татгалзсан 1,185 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
3. **Компанийн дүрмийг батлах:** зөвшөөрсөн 682,622,579 ширхэг хувьцаа буюу 99.99 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 28 ширхэг хувьцаа буюу 0.01 хувь байна.
4. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр өгсөн саналын тоо нь дор дурдсан тоо хэмжээтэй байна.

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Адилбиш овогтой Ганхуяг	663,547,237	10.80
2	Адилбиш овогтой Ганболд	662,885,461	10.79
3	Гансүх овогтой Бат-Эрдэнэ	839,977,047	13.67
4	Очирбат овогтой Батмөнх	662,775,553	10.79
5	Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ	662,768,523	10.79
6	Ганболд овогтой Чинзориг	663,095,171	10.79
Хараат бус гишүүд			
1	Равжин овогтой Ганболд	662,985,891	10.79
2	Чулуун овогтой Мэргэн	662,770,016	10.79
3	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	662,798,564	10.79

ДУГААР 151011
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилж, Компанийн оноосон нэрийн ард Компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК" гэсэн ялгах тэмдэглэгээтэй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчилсөн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Тогтоол 2: Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн оршин байгаа хаягийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Тогтоол 3: Компанийг дүрмийг батлах

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд

ДУГААР 151011
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Тогтоол 4: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбиш овогтой Ганхуяг,
 - (ii) Адилбиш овогтой Ганболд,
 - (iii) Гансүх овогтой Бат-Эрдэнэ,
 - (iv) Очирбат овогтой Батмөнх,
 - (v) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ,
 - (vi) Ганболд овогтой Чинзориг.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Равжин овогтой Ганболд,
 - (ii) Чулуун овогтой Мэргэн,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга Хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ

ДУГААР 151011
ОГНОО 2021 оны 12-р сарын 28-ны өдөр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Т.Гантулга